

Тойм ба үндэслэл

<p>Үзүүлэлт</p>	<p>26. Соёлын биет бус өвийн сан нь хамгаалалт, олон улсын оролцоог үр дүнтэй дэмждэг (энэ үзүүлэлтийг дэлхийн түвшинд Нарийн бичгийн дарга нарын газраас хянаж, мэдээлдэг).</p>	
<p>Үнэлгээний хүчин зүйлүүд</p>	<p>Энэ үзүүлэлтийг Тамгын газраас хянаж, мэдээлсэн дэлхийн түвшний гурван хүчин зүйлд үндэслэн үнэлдэг:</p>	
	<p>26.1 Оролцогч улсууд СББӨ-ийн сангаас санхүүгийн болон техникийн туслалцаа авч, тэрхүү тусламжийнхаа ач тусаар хамгаалалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.</p>	<p>Зүйл 19, Зүйл 21</p>
	<p>26.2 Оролцогч улсууд эсвэл бусад байгууллагууд голчлон дэлхийн даяар чадвар чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийг дэмжихэд зориулж СББӨ-ийн санд ерөнхий болон тодорхой зорилгуудын дагуу, сайн дурын нэмэлт хандив өгдөг.</p>	<p>Зүйл 25.5, Зүйл 27 ODs 68-71</p>
	<p>26.3 СББӨ-ийн сан нь Конвенцийн удирдах байгууллагуудын хуралд уригдсан зөвлөлдөх үүрэг хүлээсэн бүхий түүнд оролцож буй хөгжиж буй орнуудын СББӨ-ийн мэргэжилтнүүд, магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагууд, төрийн болон хувийн байгууллагууд, түүнчлэн олон нийт, бүлгүүдийн гишүүд зэрэг өргөн хүрээний оролцогч талуудын туслалцаа, дэмжлэгээгээр тус хурлыг санхүүжүүлэх зорилготой юм.</p>	<p>Зүйл 8, Зүйл 9 OD 67</p>

**ТХЗ болон
бусад
холбогдох
үзүүлэлтүүд**

Тогтвортой хөгжлийн зорилтууд: ТХЗ-ууд нь олон улсын хамтын болон тусламжын ажиллагааг, (санхүүгийн тусламжийг оролцуулан) дэмжихэд чиглэгдэж байгааг харгалзан энэхүү үзүүлэлт нь хэд хэдэн зорилго, зорилтыг дэмжиж байдаг. Тухайлбал, ТХЗ Зорилт 1.а нь "хөгжиж буй орнууд, ялангуяа буурай хөгжилтэй орнуудад ядуурлыг бүх талаар арилгах бодлогуудыг болон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хангалттай, урьдчилан таамаглах боломжыг нээж өгөх арга хэрэгслээр хангахын тулд хөгжлийн хамтын ажиллагааг сайжруулах замаар янз бүрийн эх үүсвэрээс нөөцийг ихээхэн дайчлах явдал'-ын тухай байдаг юм. Түүнчлэн ТХЗ-ын Зорилт 10.б нь "Хэрэгцээ их байгаа, ялангуяа буурай хөгжилтэй, Африкийн, жижиг арлын болон хөгжиж буй, ба далайд гарцгүй хөгжиж буй улс орнууд"-д санхүүгийн туслалцаа үзүүлэхийг онцгойлон авч үздэг бол ТХЗ 17.3-т "хөгжиж буй орнуудад санхүүгийн нэмэлт эх үүсвэрүүдийг дайчлах" зорилгыг өөртөө тусгасан байдаг ба ТХЗ-ын зорилт 17.9 нь хөгжиж буй орнуудын чадвар, чадавхийг бэхжүүлэх олон улсын дэмжлэгийн талаарх агуулгатай байдаг. Үнэлгээний хүчин зүйл 26.3 нь ТХЗ Зорилт 16.8, болох "дэлхийн засаглалын институцид хөгжиж буй орнуудын оролцоог өргөжүүлэх, бэхжүүлэх" зорилтыг дэмждэг. Мэдээж хэрэг, энэхүү үзүүлэлт нь ТХЗ-ын 11.4 зорилт буюу "Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах, хамгаалах хүчин чармайлтыг бэхжүүлэх"-ийг мөн дэмжиж байна.

Бусад үзүүлэлтүүдийн хамаарал: Соёлын биет бус өвийг хамгаалах сангаас (СББӨ-ийн сан) үзүүлдэг тусламжийг бүх төрлийн хамгаалах хөтөлбөрүүдэд ашиглаж болох тул энэхүү үзүүлэлт нь хамгаалах онцгойлсон үйл ажиллагаатай холбоотой бусад хэд хэдэн үзүүлэлтийг хэрэгжүүлэ байна. Дэлхийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийг дэмжих талаар тусгайлан дурдвал энэхүү үзүүлэлт нь 2, 3-р үзүүлэлтийг мөн хэрэгжүүлж байна. Үнэлгээний хүчин зүйл 26.3 нь Үзүүлэлт 23-ыг буюу хорооноос зөвлөх буюу зөвлөлдөөнөөр оролцохоор уригдан ирсэн оролцогчдод хамаарах үзүүлэлтийг хэрэгжүүлж байна.

<p>Үйл ажиллагааны үндэслэл</p>	<p>24, 25 дугаар үзүүлэлтүүдийн талаар дурьдсанчлан, конвенцийн дөрвөн зорилгын нэг нь “олон улсын хамтын ажиллагаанд туслалцаа үзүүлэх” (1(d) зүйл) бөгөөд конвенц нь цаашлаад Соёлын биет бус өвийг хамгаалах улс орнуудадын хүчин чармайлтад тусламж үзүүлэх талаар “олон улсын хамтын ажиллагаа”-нд нэмж оруулахыг тусгасан байдаг(19-р зүйл). Ийм тусламжийг дэмжихийн тулд конвенц нь СББӨ-ийн санг байгуулж, улс орнуудыг жил бүр төлдөг дэмжлэгээсээ гадна сайн дурын нэмэлт шимтгэл хийхийг уриалж байдаг ба (27-р зүйл) эдгээр шимтгэлийг ерөнхий болон онцой зорилгоор ашиглаж болно (Зүйл) 25.5). Удирдах байгууллагууд ийм нэмэлт хандивын гол чиглэл болгож, түүгээрээ чадвар чадавхийг бэхжүүлэхэд онцгой ач холбогдол өгч байна. Эцэст нь тус хороо нь "Газарзүйн янз бүрийн бүс нутгийн хороонд шударга төлөөллийг хангахын тулд" өөрийн үйл ажиллагааны дүрэмдээ СББӨ-ийн өргөн хүрээний, ялангуяа гишүүд оролцогчдыг хуралдаанд оролцуулахад шаардлагатай санхүүгийн туслалцааг хөгжиж буй орнуудаас үзүүлэхийг заасан байдаг.</p>
<p>Гол нэр томъёо</p>	<ul style="list-style-type: none"> · Оролцогч талууд · Төрийн бус байгууллагууд · Олон нийт, бүлгүүд эсвэл зарим тохиолдолд хувь хүмүүс

Хяналт-шинжилгээ хийх, үе үе тайлагнах тухай тусгай заавар

<p>Хяналтын ашиг тус</p>	<p>Энэ үзүүлэлтэд дэлхийн түвшинд хяналт тавих нь тус хороонд СББӨ сангаар дамжуулан үзүүлж буй тусламжийн үр нөлөөг үнэлэхэд тусалж, нэг болон бусад бүс нутагт хөгжиж буй орнуудын оролцоог хязгаарлаж болзошгүй саад бэрхшээлүүдэд анхаарлаа хандуулахад туслалцаа үзүүлж чадна. Дэлхийн түвшний хяналт-шинжилгээ хийх нь хандивлагч орнуудын чиг хандлагыг тодруулж, мөн санхүүжилтийн боломжит дутагдлуудыг тогтоох боломжтой болгож өгөх ба, ингэснээр Хороонд нэмэлт шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах боломжийг үүсгэж өгнө. Эцэст нь, Конвенцийн удирдах байгууллагуудын хуралдаанд оролцоход дэмжлэг үзүүлэхэд олон талын оролцогч талууд хяналт тавих нь хамгийн өргөн хүрээний оролцоог хангахад тусална.</p>
---------------------------------	---

Мэдээллийн эх сурвалж, цуглуулга

Энэхүү үзүүлэлтийг Тамгын газар дэлхийн түвшинд хянадаг бөгөөд энэ цаашлаад нь СББӨ-ийн сан, түүний орлого (сайн дурын нэмэлт шимтгэлийг оруулаад) болон зарлагын (олон улсын тусламж болон удирдах байгууллагуудын хуралдаанд оролцоход шаардлагатай зардлыг дэмжих) талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий мэдээллийн сан болон бусад хэрэгслийг хөтөлдөг. Нарийн бичгийн дарга нарын газрын мэдээллийн сан нь санхүүжилтийн хүсэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг конвенцийн вэб сайтад нийтлэхийг мөн адил дэмждэг. Олон улсын тусламжийн үр дүнд бий болсон үйл ажиллагааг ашиг хүртэгч оролцогч улсууд хороонд үүнийгээ тогтмол тайлагнадаг (24.3-р зүйл); Иймэрхүү тайлангууд нь Конвенцийн вэб сайтад бас байршуулагдсан байдаг.

Боломжит мэдээллийн эх сурвалжууд

- Тамгын газраас хөтөлдөг мэдээллийн сан болон бусад хэрэгслүүд
- Хүлээн авсан олон улсын тусламжийн талаар ашиг хүртэгч оролцогч улсуудаас хороонд өгсөн тайлан